

## САНАЛ

*НДЕГ-ын 2026 оны 1-р сарын 14-ний өдрийн*

*01//113 дугаартай албан бичгийн харуу*

2026 оны 1-р сарын 20.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д тэтгэврийн нөөц сантай байх тухай заасан байдаг. НДЕГ-аас хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2024 онд тэтгэврийн нөөц санд мөнгөн хөрөнгө татан төвлөрүүлсэн бөгөөд энэхүү хөрөнгөө Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор батлагдсан журмын 4 дэх хэсэгт заасны дагуу засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийж байршуулах саналаа НДҮЗ-ын Ажлын албаар уламжлан Мэргэжлийн хороонд ирүүлсэн байна.

Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд байршуулах үйл ажиллагаанд Мэргэжлийн хороо оролцож эрсдэлийн түвшинг үнэлж, дүгнэлт гаргах эрх үүрэг хууль тогтоомжоор бидэнд олгогдоогүй. Гэвч тэтгэврийн нөөц сан нь нийгмийн даатгалын сангийн нэг хэсэг болохын хувьд бид ирүүлсэн хүсэлт холбогдох баримт материалтай танилцаад эрсдэлийн түвшингээр хамгийн бага гэж үнэлэгддэг Засгийн газрын үнэт цаасыг худалдан авах та бүхний саналыг Мэргэжлийн хороо дэмжиж байна.

Засгийн газраас гаргах үнэт цаасны арилжаанд нийгмийн даатгалын байгууллага оролцох боломж, цаг хугацааны талаар сайтар судалж, эрх бүхий байгууллагуудтай урьдчилан тохиролцсон гэдэгт итгэж байна.

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ  
ОРОН ТООНЫ БУС МЭРГЭЖЛИЙН ХОРОО**